

Баасанжаргал Бямбаагийн[✉]

¹Шинжлэх Ухааны Академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах эрх зүйн орчин бүрэлдэн тогтсон түүхийн асуудалд (1921-1992 он)

Abstract. This article aims to briefly describe how the state and government have resolved the issues of preserving, registering, researching, promoting, and restoring historical and cultural monuments within the legal framework since the establishment of the central organization for modern scientific organization in Mongolia (1921), until the period of the Mongolian People's Republic (1992). State policy and activity in this area, which began with the registration of ancient monuments by the Scientific Committee, were subsequently based on legal acts, beginning with the "Rule on the Preservation and Protection of Antiquities," adopted in 1924. In the Constitution of Mongolia (1992) indicates "Historical and cultural monuments, the scientific and intellectual heritage of the Mongolian people are under the protection of the state."

Keywords: law, rule, historical and cultural monuments, preservation, protection

Аливаа үндэстэн уламжлалт түүх, соёлын дурсгалт эд өлгийн зүйлсээ эрхэмлэн дээдэлж төрийн хамгаалалтад байлгаж ирсэн нийтлэг жишгээр Монгол Улс одоо үйлчилж буй Үндсэн хуульдаа "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв, төрийн хамгаалалтад байна" гэж заасан байдаг.

1921 оны Үндэсний ардчилсан хувьсгал ялснаар Монгол Улсад хөгжлийн шинэ үе эхэлж, Ардын Засгийн Газраас боловсрол, соёлыг хөгжүүлэх талаар ихээхэн анхаарах болсон.

Судар бичгийн хүрээлэнг байгуулан, дүрэмд нь "...Монгол газрын элдэв зүйлийн хуучин ном судруудыг олж бүрэн бүтэн хадгалах ба монгол үндэстэнд чухал холбогдох хэргийн бичигтэй хөшөө, чулууны зэрэг зүйлүүдийг батлан хамгаална" хэмээн заасан нь соёлын өвийг хадгалж хамгаалах, цуглуулах, эрэн сурвалжилж цуглуулах, бүртгэж данслах ажил эхэлж үндэсний түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, судлан шинжлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх боломж бүрэлдсэн байна.

Улмаар тус хүрээлэнгийн эрдэмтдийн гаргасан саналын дагуу Ардын Засгийн Газар 1924 оны 9 сард "Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм"-ийг 10 зүйлтэйгээр батлан гаргажээ. Уг дүрмийг 1925 онд Судар бичгийн хүрээлэнгээс эрхлэн Улаанбаатар хот дахь Орос, Монгол хэвлэлийн

газарт монгол, орос, англи хэлээр 500 хувийг хэвлүүлсэн нь тухайн үед англи хэлээр хэвлэсэн цөөхөн хууль, дүрмийн нэг байв.

Дүрэмд "... Монгол Улсын хязгаарын дотор бий бүх хуучны дурсгал болох зүйл цөм Монгол Улсын өөрийн хөрөнгө мөн" хэмээн зааж, хуучны дурсгалт зүйлс хэмээх ойлголтод багтах зүйлсийг

Нэг. Эх түүхэнд холбогдох бичиг зураг бүхий ба бичиг зураггүй булш, чулуун хөрөг, жич зураг бичигтэй ба зураг бичиггүй хад байц чулуун пайлуур багана зэргийн зүйл, хуучин цагийн зоосны аймаг,

Хоёр. Чулуу шороо овоолго зэргээр үйлдсэн булшнууд бүх хэрэгслийн хамт,

Гурав. Эрт цагийн эвдэрхий хот балгас зэрэг зүйл,

Дөрөв. Орон сав зэрэг эртний түүх ба онгон тахилгад холбогдох урлан үйлдсэн зүйл,

Тав. Музейд агуулбал зохих археологи хэмээх хуучин байдлын юм ба газар доороос олдох палеонтологи хэмээх эрт цагийн ургамал ба амьтны үлдэгдэл зэрэг юмс,

Зургаа. Хуучны суртал заншлыг мөрдөж ард олноор сахиж хамгаалсаар ирсэн онгон дархан уул, цаазтай ой хөвч, хэсэг мод ба урд насны ганц нэг мод,

Долоо. Олон зүйлийн ховор амьтан (Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм, 1924) зэрэг долоо

хуваан ангилж, тэдгээртэй холбогдуулан археологи, палеонтологи хэмээх юу болох тухай шинжлэх ухааны тайлбар өгсөн байна.

Хамгийн гол нь тус дүрмээр түүх, соёлын дурсгалт зүйлсийн асуудлыг Судар бичгийн хүрээлэнд хариуцуулсан нь асуудал төрийн байгууллагын мэдэлд ирж, хуулиар хамгаалагдах эхлэл болсон гэж үзэх боломжтой. Энэ утгаараа “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм” нь тухайн салбарын анхны эрх зүйн баримт бичиг мөн.

Хүлээсэн үүргийн дагуу Судар бичгийн хүрээлэн нь Туул голын сав дагуу эртний элдэв сонин зүйлийг эрж шинжлэх тусгай эрдэмтдийг томилон ажиллуулах (Хураангуй сэтгүүл, 1922), хот суурины үлдэгдэл, булш бунхан, аймаг орон нутагт буй байгаль, түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх, данс тодорхойлолт үйлдэх, олон албаны газар болон хувь хүмүүсийн гар дээр хадгалагдаж байсан хуучны эд зүйлийг шилжүүлэх болон худалдаж авах зэргээр хадгалж хамгаалах, данслан цэгцлэх, судлах, нийтэд сурталчлан таниулах ажлыг хийж эхэлжээ.

Тухайлбал, Судар бичгийн хүрээлэнгийн Тэргүүлэгчдийн 1925 оны 1 сарын 18-ны өдрийн 1-р хурлын тогтоолоор, Хуучны дурсгалт зүйлсийг хэрхэн хамгаалах талаар хэлэлцээд “... Хөшөө цайдам, Налайх, Хэсэг байшингийн бичигт чулууны зүйлээс болох зохихыг үзэж, авч ирүүлэн музейд агуулсугай” (Шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхэнд холбогдох баримт бичиг, 1956) хэмээн тогтож, тэдгээрийг шинжлэн үзэх, зураг үйлдүүлэхээр хүрээлэнгээс хүмүүс томилж ажиллуулж байжээ.

Үүний зэрэгцээ Судар бичгийн хүрээлэнгээс чухалчлан үзэж байсан нэг асуудал нь Монгол Улсад ирсэн гадаад улсын шинжилгээний ангиудад тус улсын хууль цаазад нийцсэн үйл ажиллагаа явуулах, “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг дагаж мөрдөхийг онцлон анхааруулж, холбогдох гэрээ хэлэлцээг байгуулан ажиллаж байжээ.

Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах анхны дүрэм нь агуулгын хувьд товч, ерөнхий шинжтэй байсан хэдий ч, тухайн салбарын эрхзүйн орчныг бүрдүүлэх эх суурийг тавьж, түүний үндсэн гол санаа дараа дараагийн үед гарсан хууль, дүрэм зэрэгт тусгалаа олсныг тэмдэглэх ёстой.

Мөн 1925 онд хуралдсан МАХН-ын IV их хурлаар түр баталсан тус намын Мөрийн хөтөлбөрийн “Тэгээрүүлэх явдлын тухай” нэртэй тусгай бүлэгт эх хэл, үсэг бичиг, ерөнхий эрдэм, шинжлэх ухаан, соёл, урлагийг хөгжүүлэх талаар маш тодорхой заалтууд багтсан нь урт хугацаандаа түүх, соёлын талаар баримтлах бодлого болсон хэмээн үзэж болно.

Судар бичгийн хүрээлэн 1930 онд Шинжлэх ухааны хүрээлэн (*цаашид ШУХ гэж товчилно*) болж өргөжсөнөөр монголын түүх, соёлын өвийг хадгалж хамгаалах үндэсний тогтолцоог бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэн, судалгаа шинжилгээний ажил цар хүрээгээ тэлж, гадаад харилцаа идэвхжиж ирсэн тул салбарын хууль эрхзүйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлага ч нэмэгджээ.

Энэ чиглэлд хийгдэх нэн чухал ажил нь түүх, соёлын дурсгалт зүйлсийн хадгалалт, хамгаалалтын асуудлыг зохицуулах дүрэм журмыг сайжруулах, тодорхой болгох явдал байв. Учир нь “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг олон нийтэд хүргэх, тайлбарлан таниулах ажил сул байсны улмаас албан байгууллага, ард иргэд түүх, соёлын дурсгалт зүйлсийг зоргоор эвдлэх, хиргисүүр, булш бунхныг хулгайгаар ухаж, олдсон эд өлгийн зүйлийг зарж борлуулах тохиолдол зарим аймагт гарсан нь эх түүхийн дурсгалууд үрэгдэж үгүй болох аюулыг бодитоор бий болгожээ.

Тиймээс БНМАУ-ын Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч сайд Х.Чойбалсангаас 1935 оны 10 сарын 1-нд гаргасан 135 тоот тушаалд: “... Худалдаа, Үйлдвэрийн Яамнаас бусдад булш малтах зөвшөөрлийг хяналтгүйгээр өгч, булш хууль бусаар малтуулан ухаж үймүүлсэн нь туйлын үл зохисон хэрэг болох”-ыг тэмдэглэж, “... зөвшөөрөл өгөх явдлыг шууд бүрмөсөн зогсоож, хот, хөдөөгийн засаг захиргааны албан газрууд, ард иргэд зөвхөн ШУХ-ийн зөвшөөрлөөр малтах, ... Хуучин зүйлийг сахин хамгаалах дүрмийг сайтар дагаж мөрдөх”-ийг (МУҮТА. ТБА. Х-23, Д.1, Хн.137, Х.17, 1935) онцлон заасан байна.

Үүнтэй холбоотойгоор, 1935 онд ШУХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга М.И.Тубянский, Түүхийн тасгийн ажилтан Д.Нацагдорж нарын эрдэмтдээс Орхоны Хөшөө цайдамд бүхий эртний Түрэгийн Билгэ хаан, Культегины хөшөө, Налайх орчим дахь Тоньюкукийн гэрэлт хөшөөнд хамгаалалтын барилга, хайс бариулах, эдгээрийг хэрхэн хамгаалалтад авах, ямар барилга барих талаар холбогдох зургийг үйлдэн хавсаргаж, уг ажлыг эрэмбэ дараатай хийх саналыг боловсруулан хүрээлэнгийн Тэргүүлэгчдэд хүргүүлж байсан байна.

Мөн орон нутаг болон бусад холбогдох байгууллагууд хангалтгүй ажиллаж байгаа талаар эрдэмтэн Ш.Нацагдорж “Тус улсын уужим нутагт өнгөрсөн үеийн түүхийг судлахад маш чухал гэрч баримт болох ба бүх дэлхийн шинжлэх ухаанд алдартай болсон хуучин бичигтэй хөшөө, хиргисүүр, эртний балгас, хэрэм, булш маш үлэмжхэн бөгөөд эдгээрийн зарим нэгийг олж бүртгэсэн ба сахиж хамгаалах талаар ажлыг зохиож буй боловч ихэнх нь ямар ч хамгаалалт

үгүй хөсөрдөн хэвтэж байна. Засгийн Газраас тус улсын газар дэвсгэр дээр буй бүхий л түүхийн дурсгалт зүйлийг сахиж хамгаалах ба хамаа бус эвдэж сүйтгэхэд хүргүүлж үл болох тухай 14 онд [1924] зориуд дүрэм хэмжээ тогтоож дагаж шийтгүүлэхээр явуулсан байна... Гэтэл тус ШУХ-ийн орон нутгийн байгууллагууд энэхүү дүрмийг сулаар биелүүлснийг харахаар одоо дэлхий дахинд дахин олддошгүй ховор хөшөө чулуу, хот балгасын үлдэгдэл нь он өнгөрүүлэх тутам үрэгдэж сарниж байна (Ш.Нацагдорж, 1941) гэж шүүмжлэн бичжээ.

Цаашид тус хүрээлэнгийн Түүхийн тасгаас, 1924 онд баталсан дүрмийг олон нийт, орон нутгийн байгууллагууд ёсчлон биелүүлэхгүйн улмаас хуучны дурсгалт зүйлүүд хариуцах эзэнгүй, хөсөр хаягдан, эвдэрч сүйдэхэд хүрч байгааг харгалзан, уг дүрмийг шинэчлэн боловсруулж Улсын Бага Хурал (*цаашид УБХ гэж товчилно*)-ын Тэргүүлэгчдийн газарт хүргүүлсэн байна.

УБХ-ын Тэргүүлэгчдийн газар ШУХ-ээс ирүүлсэн дүрэм, түүхийн дурсгалт зүйлийн тодорхойлолтыг үндэслэн, 1941 оны 11 сарын 13-ны өдрийн 79-р тогтоолоор “**Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм**”-ийг шинэчлэн баталжээ. (Улсын Бага Хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолууд. Нэгдүгээр, хоёрдугаар эмхэтгэл дэвтэр., 1941)

Шинэчилсэн дүрэмд орсон өөрчлөлтийг авч үзвэл:

1. 1924 оны дүрэмд байсан хуучны дурсгалт зүйл болох “олон зүйлийн ховор амьтан” гэсэн ангиллыг хасаж, бусад 6 ангиллыг өөрчлөлгүй хэвээр үлдээсэн,

2. Шинэ дүрэмд “Урлал ба этнографи соёлын талаар үнэтэй зүйлүүд бүхий хуучны дурсгалыг шинжлэх буюу ухаа ажлыг...” гэсэн нэмэлт оруулж, урлал, этнографи гэх нэр томъёог анх хэрэглэсэн,

3. Түүхийн дурсгалт барилгыг ашиглахдаа хадгалалт хамгаалалт, сэргээн засварлаж байхыг баталсан гэрээг ШУХ-тай байгуулж байх,

4. Улсын нэгдүгээр зэргийн хамгаалалтад авах дурсгалын бүртгэлийг баталсан. Үүнд:

ШУХ-ээс тогтоосон ангилалд Туулын цагаан байшин, Эрдэнэ зуу хийдийн Хархорин, Амарбаясгалант хийд, Эрдэнэ зуу, Гүнжийн сүм, Тугийн сүм, Даян дээрхийн сүм, Чингисийн хэрэм, Чин толгойн балгас, Орхоны хар балгас, Хэрлэн барс хот зэрэг эртний хот балгас, хэрмийн үлдэгдэл дурсгал, Дөрвөлжингийн хиргисүүр, Ноён уулын булшнууд, Налайх дахь Тоньюкукийн хөшөө зэрэг бичигт хөшөө, сүм хийд зэрэг нийт 30-аад дурсгалыг нэгдүгээр зэргийн хамгаалалтад авч бүртгэжээ.

Түүнчлэн ШУХ-нд түүхэн дурсгалт зүйлийг хариуцан ажиллах тусгай төлөөлөгч томилох, аймаг орны нутаг дэвсгэрт буй түүх соёлын

дурсгалт зүйлсийн жагсаалтыг үйлдэж ШУХ-д ирүүлэхийг аймгийн дарга нарт даалгасан зэрэг нь шинэ дүрмийн ололттой тал байв.

Дараагийн чухал арга хэмжээ нь 1941 оны эцсээс МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөл (*цаашид АСнЗ гэж товчилно*)-өөс түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, сэргээн засварлах талаар анхаарч цаашдын чиг зорилт, зохион байгуулалтыг өргөжүүлэхтэй холбогдсон тогтоол гаргаж, томоохон арга хэмжээнүүдийг авч, УБХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас хуучны дурсгалт зүйлсийг хамгаалах, цуглуулах, сэргээн засварлахад хөрөнгө гаргахаар шийдвэрлэж, 71-р хуралдаанаас Эрдэнэ зуу хийдийг сэргээн засварлах ажлыг эхлэх, зардал мөнгө, үнэлгээ хийх чиглэл өгсөн боловч цаг үеийн нөхцөл байдлын улмаас хойшилсоор, АСнЗ-ийн 1944 оны 5 сарын 19-ний өдрийн хурлаас “Эртний Монгол Улсын нийслэл Хархорин, Эрдэнэ зуугийн сүмийг онцлон үзэж сэргээн засварлах тухай” 63-р тогтоол гарснаар ажлыг эхлүүлсэн байна. (Соёл-гэгээрлийн байгууллагуудын ажлын талаар холбогдолтой зарлиг, тогтоол, заавруудын системчилсэн эмхэтгэл (1940-1961), 1962, хууд. 198)

Хэдийгээр засаг төрөөс тодорхой арга хэмжээнүүдийг авч байсан боловч асуудал эрхэлсэн байгууллага болон зарим нутгийн албан байгууллагаас ард иргэдэд “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийн талаар олон нийтэд ухуулан таниулах ажил хангалтгүйн улмаас түүх соёлын дурсгалд хүйтэн цэвдэг хандах явдал үргэлжилсэн хэвээр байжээ.

Улаанбаатарын орчим Их тэнгэр, Зайсан, Чулуут, Хүрхрээ, Жаргалантын ам, Алдар, Толгойтын Баянхошуу зэрэг газарт байсан эртний булш, хиргисүүрүүд, мөн Гачуурын амны бичиг зураг, Булган аймгийн нутагт орших Хун-Тайжийн балгас, мөн аймгийн Бүрэгхангай орчимд байдаг Туулын цагаан байшин, Чойбалсан аймгийн нутагт байсан Тугийн сүм зэргийг зориуд эвдэж устгажээ. Энэ мэтээр Архангай, Өмнөговь, Төв, Хэнтий зэрэг аймгийн нутагт хиргисүүрийг зохих зөвшөөрөлгүйгээр устгасан явдал гарч байв.

Мөн улсын нэгдүгээр зэргийн хамгаалалтад багтсан Төв аймгийн Эрдэнэ сум дахь Гүнжийн сүмийн доторх түүхийн дурсгалт зүйлсийг тоносон, Өвөрхангай аймгийн Өлзийт сум дахь Бууралын хөшөөг эвдэн сүйтгэсэн, Сүхбаатар аймгийн Онгон сумын “Алтан-Овоо” гэдэг газрын ойролцоо байсан цагаан гантиг чулуугаар хийсэн хөшөөнүүдийг 1943-1944 оны үед эвдэн сүйтгэсэн, 1955 онд Архангай аймгийн Их Тамир сумын хариуцлагатай ажилтан нар нутгийн хүмүүсийн хадгалж байсан хуучин ном судрыг харгис хуучны юм гэж буруушаан устгуулсан зэргээс үндэслэж төрөөс бодлого, зохион байгуулалтын томоохон

арга хэмжээнүүдийг авахад хүргэсэн байна. Үүнд:

БНМАУ-ын Ардын Их Хурлын (*цаашид АИХ гэж товчилно*) Тэргүүлэгчдийн 1956 оны 6 сарын 1-ны 57-р зарлигаар Урлагийн хэрэг эрхлэх хороог Соёлын Яам болгон өргөжүүлэн зохион байгуулж, түүний эрхлэх ажил, үүрэгт түүх, соёлын дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих явдлыг багтаасан байна. Мөн МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны (*цаашид ТХ-ны УТТ гэж товчилно*) 1956 оны 10 сарын 23-ны өдрийн хуралдаанаас “Соёлын өвийг хамгаалах тухай” 346-р тогтоолыг гаргаж “...Өөрийн улсын ба эртнээс нааш зэргэлдээ оршиж байсан хөрш улсуудын өнгөрсөн үеийн нийгэм, соёлын байгуулалт, тэр үеийн ард түмний зан заншил, ёс суртахууныг судлах явдалд хуучны ном бичиг, түүх дурсгалын зүйлүүд нь онц их ач холбогдолтой, ...одоогийн шинэ соёлыг хөгжүүлэх зорилтын нэг чухал хэсэг болгож Монголын эртний соёлын өвийг хайш яаш үзэх, түүнийг устгах, үрэгдүүлэх явдалтай тэмцэх ёстой” (МАХН-аас урлаг-утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэрүүд (1921-1966), 1967, хуудсд. 151-152) хэмээн тэмдэглэсэн нь ажил идэвхжихэд нөлөөлжээ.

Тогтоолын дагуу түүх, утга зохиол, ард түмний зан заншилтай холбоотой хуучны ховор судар, ном бичгүүдийн жагсаалтыг гаргаж, тэдгээрийг Орон нутгийг судлах кабинет, соёл гэгээрлийн бусад газруудаар уламжлан нийтэд зарлаж, дурсгалт зүйлүүдийг цугларуулах ажлыг зохиож, соёлын өвийг хайрлан хамгаалах, арчлан хадгалах талаар яриа таниулгын сэдвүүд боловсруулан түгээж, эрдэмтэн Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Б.Цэдэн нар тухайн сэдвээр өгүүлэл нийтлэл бичиж ном, сонин сэтгүүлд цувралаар хэвлүүлж байв. Нэгэн жишээг дурдахад, эрдэмтэн Ц.Дамдинсүрэн 1956 онд “Соёлын өвийг анхаарч үзье” гэсэн томоохон өгүүлэл бичиж, тодорхой баримт, мэдээг олны анхааралд хүргэхийг зорьсон байдаг. (Ц.Дамдинсүрэн, 1956)

Гэвч төр намын удаа дараагийн тогтоол шийдвэрүүдийг хөдөлмөрчдөд сурталчлан таниулах, судлуулах ажил орон нутагт хангалтгүй хийгдэж, соён гэгээрүүлэх ажлын нөлөө бага байсан нь түүх, соёлын дурсгалт зүйлсийг эвдэж гэмтээхийн эсрэг эрс шийдвэртэй арга хэмжээ авахад хүргэж, БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 101-р зүйлд “...түүх, соёл-урлаг, байгалийн дурсгалт зүйлийг анх удаа гэмтээсэн, санаатайгаар устгасан буюу эвдлэн сүйтгэсэн гэм буруутай хүнийг нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу албадан ажил хийлгэх, эсвэл 1000 төгрөг хүртэл торгож шийтгэнэ” гэсэн нэмэлт оруулж, МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1957 оны 54-р тогтоолоор баталсан байна. (МУҮТА. УТНОНББА. Х.-4, Д-23, Хн-199, х.176-177, 1957)

Тогтоолд: Амарбаясгалант, Эрдэнэ зуу, Чойжин ламын сүм, Богдын ордон зэрэг түүх дурсгалын эртний уран барилгууд нь жилээс жилд гэмтэж муудаж байгааг дурдаад, дурсгалт барилгуудыг засварлах талаар арга хэмжээ авах, түүх дурсгалын бүх зүйлүүдийг тодорхой бүртгэж улсын хамгаалалтад авах талаар санал боловсруулж 1957 оны 12 сарын 1-ний наана Сайд нарын Зөвлөлд (*цаашид СнЗ гэж товчилно*) оруулахыг холбогдох байгууллагад үүрэг болгожээ.

Мөн 1941 онд баталсан дүрмийн хавсралт дээр нэмж улсын хамгаалалтаас гадна орон нутгийн засаг захиргааны байгууллагын хамгаалалтад байх түүхийн дурсгалын жагсаалтыг гаргаж, ШУА-ийн харьяанд улсын нэгдүгээр зэргийн хамгаалалтад байх 12 дурсгал, аймаг, хотын Ардын Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргаа (*цаашид АДХТЗ гэж товчилно*)-ны харьяанд хоёрдугаар зэргийн хамгаалалтад орох 30 дурсгалын жагсаалтыг тус тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар баталжээ. (Соёл-гэгээрлийн байгууллагуудын ажлын талаар холбогдолтой зарлиг, тогтоол, заавруудын системчилсэн эмхэтгэл. (1940-1961), 1962, хуудсд. 206-208)

Дээрх тогтоол шийдвэрүүд батлагдсанаас 2 жилийн дараа 1959 оноос эхэлсэн Соёлын довтолгооны жилүүдэд улс орны эдийн засаг, соёлын амьдрал, ахуйд бий болж байсан шинэ зүйлүүдийн зэрэгцээгээр, сөрөг үзэгдлүүд ч гарч байсан нь чухамхүү түүх соёлын зүйлсэд хамаарах юм. Учир нь нам, эвлэлийн гишүүд айл өрхүүдээр явж шашны хор уршгийг ухуулах, бурхан тахилыг нь буулгуулах, хураах зэрэг компани ажлыг явуулж байсны улмаас ард иргэд үе дамжин уламжлагдан ирсэн бурхан тахилаа хуучны ном судар, эд зүйлсээ өөрсдөөс зайлуулан уул хаданд аваачин нуух, газарт булах, устгах үзэгдэл энд тэндгүй гарч, ялангуяа хөдөө орон нутагт ихээр үрэгдэх болсон талаар олон жишээг дурдаж болно. Тухайлбал, “Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын 4 дүгээр бригадын дарга Мягмар, үхрийн фермийн дарга Махбал нар бригадын гишүүдийг хуралдуулан, соёлын довтолгооны тухай танилцуулахдаа “Бид хуучин нийгмийн үзэл суртлыг бүрмөсөн халж соёлын довтолгоог эрчимтэй явуулахын тулд юуны өмнө хуучин судар ном, бурхнаа устга, үүнийг устгаж чадвал бид соёлын довтолгоог явуулж ч чадна, гурван зорилтыг биелүүлж ч чадна” (М.Шинэхүү, 1961) зэргээр олныг ухуулж байжээ.

Мөн 1950-иад оны зун Булган аймгийн Ингэт толгойн өвөрт байх “Далхвандад” хэмээн нэрлэдэг хүн чулуун хөшөөг Ингэт толгойн сангийн аж ахуйн намын хорооны дарга трактороор чирч Сэлэнгэ мөрөнд живүүлснийг эрдэмтэн Б.Ринчен нутгийн хүмүүсээс дуулж мэдээд, уснаас гаргуулж хуучин байранд нь буцааж байрлуулсан байна.

Орон нутагт түүх соёлын дурсгалт зүйлийн мод, туйпуу, чулуу зэргийг барилга байшин, малын хашаа саравч, зам барихад ашиглахын зэрэгцээ хиргисүүрийн чулууг барилгын материал болгон авч хэрэглэх тохиолдол гарсаар байв. Жишээлбэл, "...хиргисүүр гэж танигдахгүй болгох явдал Булган аймгийн Хишиг өндөр, Гурванбулаг сумдад их гарч байна. Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Зүүн дэрсэнд ямар нэгэн булшны тэмдэг бололтой баруун гартаа дэнс, зүүн гартаа гаанс тамхи барьсан тоорцог, хүрэм өмссөн хүний маш урлагтай хийгдсэн чулуун дүрс баруун тохойгоороо газар тулан хэвтэж байсныг тэндхийн сургуулийн эрхлэгч Нямсүндэв сурагчдаар хэмхлүүлсэн, бас Орхоны урд талын худгийн дэргэдэх хаданд 2000 гаруй жилийн урьд бичигдсэн хоёр давхар хүрээтэй 40х50 см-ийн шунхан дүрс бичгийг ч гэсэн дээрхийн адил сүйтгэжээ". (Р.Равжир, 1966)

Түүнчлэн түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах талаар ард иргэдээс санал, шүүмжлэл гаргах асуудал үргэлжилсээр байсан учир төр засгаас орон нутгийн удирдлагууд харьяат дэвсгэр нутагтаа байгаа түүх, соёлын дурсгалт зүйлсийг бүртгэж баримтжуулан нарийн тодорхой данс бүртгэлтэй болгох анхаарч ажиллахыг үүрэг болгожээ.

Энэ дагуу БНМАУ-ын СнЗ-ийн 1962 оны 4 сард баталсан Соёлын Яамны дүрэмд: *"тус улсын соёл, урлагийн өв, дурсгалт зүйлийг хамгаалах ажлыг эрхлэхийн гадна, улс төр, олон нийтийн ба шинжлэх ухаан, техник, урлагийн зүтгэлтний дурсгал, хөшөө, түүхт явдлын тухай хөшөө, баримал байгуулах саналыг боловсруулж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд оруулна"* (Гэгээрэл, шинжлэх ухаан, соёлын талаар холбогдолтой хуульчилсан актуудын системчилсэн эмхэтгэл (1961-1963), 1964, хууд. 209) гэж заажээ. Дүрмийн гол заалтууд нь "орон нутгийн удирдлагууд харьяат дэвсгэр нутагтаа байгаа түүх, соёлын дурсгалт зүйлсийг бүртгэж баримтжуулан нарийн тодорхой данс бүртгэлтэй болгох, хөшөө дурсгалд хамгаалалт хийж хашаа барих, дурсгалын самбар хадах, холбогдох хууль, дүрэм, заавар, дурсгалт зүйлийг олонд таниулах ажлыг гурав, долоо хоногоор зохион байгуулах, ухуулагчдаар дамжуулан яриа танилцуулга хийх, орон нутгийн музейн ажилтнууд, орон нутгийн удирдлагууд жил бүр түүх соёлын дурсгалт зүйлс, хөшөө дурсгалын талаар ШУА-д мэдээ ирүүлж байх" гэсэн үндсэн чиглэлийг өгчээ.

Аймаг, орон нутгийн удирдлагууд тус тусын нутаг дэвсгэрт байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалалтад авах, сурталчлах, сэргээн засварлах талаар анхаарч ажиллах болсныг "...орон нутгийн сэхээтний дотроос Ховд аймгийн Дарви сум нэгдлийн дарга Даваа сум нэгдлийнхээ нутагт буй эртний дурсгалт хөшөө булш, бичигт хад мэтийг сураглан тэмдэглэж, хайрлан хамгаалах

талаар үргэлж хөөцөлддөг байна" (Б.Ринчен, 1966) гэсэн эрдэмтэн Б.Ринчений мэдээнээс харж болно.

Эх түүхийн судалгаа, сургалт, сурталчилгаа нь түүх, соёлын дурсгалыг хамгаалах асуудалтай нягт холбоотой явагдах учиртай тул БНМАУ-ын төр, МАХН-ын бодлого, үйл ажиллагаанд чухал байр суурь эзэлж, 1963 онд "Түүх дурсгалын холбогдол бүхий зүйлд хэрхэн хандах тухай" 497-р тогтоол (МУУТА. УТНОНББА. Х-4, Д.26, Хн.312, Х.188, 1963), 1964 онд "Эрдэм шинжилгээний нээлт, бүтээл, түүх дурсгалын бичиг баримтыг гадаадад гаргах буюу хэвлүүлэх журмын тухай" 114/206 тоот, 1965 онд "Хуучны дурсгалын зарим зүйлийг цуглуулан борлуулах тухай" 220/250 дугаар тогтоол (МУУТА. УТНОНББА. Х-4, Д-28, Хн-172, Х.219-220, 1966), 1966 оны 6 сард "Соёл урлагийн хуучин дурсгалт зүйлийг цуглуулах, хамгаалах тухай" 145/224 тоот (МУУТА. УТНОНББА. Х-4, Д-28, Хн-172, Х.219-220, 1966) хамтарсан тогтоолуудыг батлан гаргажээ.

Мөн, "Түүхийн дурсгалт зарим байрыг улсын хамгаалалтад авах тухай" Сайд нарын Зөвлөлийн 420-р тогтоол 1969 оны 12 сарын 19-нд гарч, Улаанбаатар хотын Консулын дэнж дэх хувьсгалт нууц бүлгэмийн байшин, Их хүрээн дэх анхны европ маягийн байшин зэрэг хувьсгалын үеийн түүхэнд холбогдох зарим барилгыг улсын хоёрдугаар зэргийн хамгаалалтад авсныг тогтоолын Хавсралтад заасан байна. Тэдгээрээр албан газар, байгууллага, сүм хийд, хөдөлмөрчдийн хувийн эзэмшилд байгаа зүйлээс соёл урлаг, түүхэн өв, түүх угсаатны зүйн холбогдолтой зүйлийг цуглуулан улсын бүртгэлд хамруулах, худалдан авах, гадаад улсад гаргах, бэлэглэх, худалдах асуудал зохицуулагдаж байв.

Энэ бүхэн нь анх 1924 онд "Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм" нэртэй баримт бичиг гарснаас хойш БНМАУ-д түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах эрхзүйн орчныг бий болгох талаар төрөөс авсан бодлого, үйл ажиллагааны үр дүн байв.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах эрхзүйн орчныг бий болгох үйл явц 1970 оноос цоо шинэ шатанд гарав. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1970 оны 10 сарын 12-ны өдрийн 167-р зарлигаар **"БНМАУ-ын соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль"**-ийг батлан, мөн оны 12 сарын 1-ээс эхлэн дагаж мөрджээ. Эл хууль гарсантай холбогдуулан УБХ-ын Тэргүүлэгчдийн 1941 оны 11 сарын 13-ны өдрийн 79-р хурлаар баталсан дүрэм хүчингүйд тооцогдох болсон байна.

Уг хууль нь түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах тухай анхны бие даасан хууль болсон бөгөөд 4 бүлэг, 20 зүйлтэй, нэр төрлөөр нь ангилан тэдгээрийг хамгаалах, ашиглах, судлан шинжлэх, сурталчлах, өвлөн эзэмших асуудлыг зохицуулсан, соёлын дурсгалт зүйлийг судлан шинжлэх, хамгаалах,

сэргээн засварлах асуудлыг төрийн бодлогоор анхаарах болсон зэрэг асуудлыг тодорхой заасан анхны бие даасан эрх зүйн баримт бичиг болжээ.

Анхны бие даасан энэ хуульд “БНМАУ-ын дэвсгэр нутгийн газрын хөрсөн дээр болон газар дор орших түүх, эртний судлал, угсаатны зүй, шашны холбогдолтой дурсгалт зүйл, урлаг, ардын уран бүтээлийн зүйл, мөн улс, олон нийт, хоршооллын байгууллагын болон соёл урлаг, шинжлэх ухааны гарамгай зүтгэлтний хувийн архивын чухал баримт бичиг, шинжлэх ухааны байгууллага, музей, үзмэрийн фондод байгаа соёлын үнэт зүйлс, номын сангийн хадгаламжид байгаа ховор ном, зохиол, хувьсгалын түүхэнд холбогдох нандин зүйл нь соёлын дурсгалт зүйлийн жагсаалтад багтана” гэж төв орон нутгийн архив, номын сан, музей, иргэдэд хадгалагдаж байгаа дурсгалт зүйлийг бүхэлд нь хамруулан хуульчлан баталгаажуулсан нь чухал ололт байв.

“БНМАУ-ын соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль”-ийн агуулга, онцлогийг авч үзвэл,

1. Түүх соёлын дурсгалт зүйлс хэмээж ирснийг *Соёлын дурсгалт зүйл* гэж ерөнхийд нь нэрлэж дотор нь ангилан хуваасан,

2. 1924, 1941 онд хэрэглэж байсан нэршлийг өөрчлөн соёлын дурсгалт зүйлийг Дурсгалт газар, Соёл-археологийн дурсгалт зүйлс, Угсаатны зүйн хэрэглэгдэхүүн, Урлагийн бүтээл, Соёлын бусад үнэт зүйлс гэсэн 5 төрөлд хувааж тус бүрт нь холбогдох дурсгалыг оруулсан,

3. Тус хуульд соёлын дурсгалт зүйлийг улсын бүртгэлд бүртгэх, хадгалалт хамгаалалтад хяналт тавихыг Соёлын Яам, аймаг хотын АДХГЗ-дад, шинжлэн судлах ажлыг ШУА-ийн зөвшөөрлөөр түүний хяналтын дор хийж гүйцэтгэх,

4. Мөн соёлын дурсгалт зүйлийг олж илрүүлсэн хүмүүст урамшуулал олгох, зохих газрын зөвшөөрөлгүй хил нэвтрүүлэх, худалдаалахыг хориглох,

5. Түүнчлэн хуульд соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах журам зөрчигчдөд этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэн хариуцлага тооцох зэрэг асуудлыг тус тус нарийвчлан заажээ.

Цаашид, СнЗ 1971 оны 12 сарын 28-ны өдөр “Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах арга хэмжээний тухай” 420-р тогтоолыг 1,2 дугаар хавсралтын хамт, мөн өдрийн 421-р тогтоолоор “БНМАУ-ын соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хуулийг биелүүлэх заавар” баталжээ. Тогтоолын хавсралтаар, Соёлын Яамнаас хариуцан хамгаалах улсын нэгдүгээр зэргийн хамгаалалтад байх 21, аймаг, хотын АДХГЗ -ны хариуцан хамгаалах хоёрдугаар зэргийн хамгаалалтад байх 107, сумдын АДХГЗ-ны мэдэлд хариуцуулах гуравдугаар зэргийн хамгаалалтад 808 зүйл бүхий дурсгалыг, нийт 936 тооны дурсгалт зүйл болсон байна.

Дээрх тогтоолтой холбогдуулан 1961 оны “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай” 524, 1969 оны “Түүхийн дурсгалт зарим байрыг улсын хамгаалалтад авах тухай” 420-р тогтоолыг тус тус хүчингүйд тооцжээ.

БНМАУ-ын Соёлын Яамны коллеги, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын хамтарсан хурлаар 1971 оны 420-р тогтоолыг биелүүлэх зорилгоор 1972 оны 6 сарын 20-ны өдөр “БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах арга хэмжээний тухай” тогтоол гаргаж (МУҮТА. ТБА. Х-13, Д-2, Хн-66. Х.153-158, 1972), “...түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх, хамгаалах, сэлбэн сэргээх ажлыг БНМАУ-ын Соёлын Яам, тэдгээрийг судлах, эрдэм шинжилгээний зөвлөгөө, удирдамжаар хангах асуудлыг БНМАУ-ын ШУА хариуцан ажиллах нь зүйтэй” хэмээн заасан байна.

Тус хамтарсан хурлаар гаргасан нэг чухал шийдвэр нь улсын болон аймаг, хотын АДХГЗ-ны хариуцан хамгаалах түүх, соёлын дурсгалт зүйлд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал тухай бүр БНМАУ-ын СнЗ-д оруулан батлуулж байх явдал байв. Мөн БНМАУ-ын түүх, соёлын дурсгалт зүйлийг заан тогтоох, ашиглан хэрэглэх, үзмэрт тавих, хувилж олшруулах зэрэг асуудлыг шийдвэрлэж байх мэргэжлийн комиссыг Соёлын Яам, ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Хэл, зохиолын хүрээлэнгүүдийн төлөөлөл, Улсын төв музейн захирал нарын бүрэлдэхүүнтэй баталж, “Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль”-ийг үндэслэн Соёлын Яамны сайдын 1972 оны 130-р тушаалаар түүх, соёлын зарим дурсгалт зүйлийг олж илрүүлэх зорилгоор Төв аймгийн Лүн сумын “Харанхуй уул” гэдэг газарт малтлага хийх зөвшөөрөл олгон, ажлын хэсэг байгуулан ажиллаж байжээ. (МУҮТА. ТБА. Х-13, Д-2, Хн-62. Х.66, 1972)

Дээрх тогтоол шийдвэрийн дагуу Соёлын яамнаас БНМАУ-ын СнЗ-ийн 1971 оны 420, 421 тоот тогтоол, зааврыг биелүүлэх үндсэн дээр Хархорум, Эрдэнэ зуу музейд түүх соёлын дурсгалт зүйлийн хамгаалалтын бүс тогтоосон БНМАУ-ын Соёлын яамны коллеги, Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хавсарсан хурлын 10/109 дугаар тогтоол, Говь-Алтай, Булган, Дундговь, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт байгаа сумдын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалтыг баталсан аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны тогтоолыг гаргуулж, Музей Удирдах Газартай хамтран Тоньюкук, Билгэ хааны хөшөөний эвдрэл гэмтлийг тодорхойлж, төмөр хашаа хийж бэхлэх, ШУА-ийн Түүхийн хүрээлэнтэй хамтран улсын 1,2-р зэргийн хамгаалалтад байгаа эртний Түрэгийн мэргэн сайд Тоньюкук, Культегин, Билгэ хааны хөшөө, Дархи эхийн сүм, Гүнжийн сүмийн хөшөөний пайз-самбарыг хийх зэрэг ажлыг хийжээ.

1972 оны сүүлээс эхлэн албан байгууллага, иргэдийн мэдэлд байгаа улсын бүртгэлээр хяналт тавьж хамгаалбал зохих түүх, соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан боловсруулсан хүснэгтийн дагуу бүртгэх, түүх, соёлын дурсгалт зүйлсийг нэг бүрчилсэн паспорттой болгох ажил эхэлжээ.

Хэдийгээр “Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль” гарсан боловч хүн чулуун хөшөө, хөшөө дурсгал, хадны сүг зураг дээр эрээчиж баллах, эртний хот балгасын үлдэц, барилга байшин, хиргисүүрийн чулуу, модыг зөөж буулгах, өөр зүйлд ашиглах зэрэг үзэгдэл хэвээр байсныг Соёлын Яаманд орон нутгаас ирүүлсэн “...Дорноговь аймагт холбогдох газрын зөвшөөрөлгүйгээр хот балгас, хүрээ хийдийн буурь туурийг хүмүүс ухаж хувьдаа ашигласан, Сайхандулаан сумын 3 дугаар бригадын дарга байсан Вандгаа гэгч малтлага хийж 6 ваар сав гаргаж гурвыг нь хагалж хагасыг нь орхисныг музейн ажилтнууд таарч олж авсан байна” (Ө.Бүрнээ, 1973) зэрэг мэдээнээс харж болно.

1976 онд хуралдсан МАХН-ын ХҮП их хурлаар нийгэм-эдийн засгийн зорилтын хүрээнд Үндэсний соёлын өвийг хамгаалах, сурталчлахад музейн байгууллагууд чухал үүрэгтэйг зааж, музейн ажлыг сайжруулах, түүх, үндэсний соёлын өвийг хамгаалах чухал зорилтыг дэвшүүлж, тодорхой арга хэмжээ авч эхэлснийг 1978 оны 11 сарын 13-ны өдрийн МАХН-ын ТХ-ны УТТ-ны хурлаас гаргасан “*Хархорин, Эрдэнэ зуугийн талаар авах зарим арга хэмжээний тухай*” 366-р тогтоол илтгэнэ. (МУҮТА. УТНОНББА. Х-4, Д-34, Хн-158, Х.246, 1978) Түүнд: түүх, дурсгалын зүйл байгаа газрын хүрээг нарийвчлан тогтоож хамгаалах, Хархорин, Эрдэнэзууг цаашид аялал, жуулчлалын үзмэрийн газар болгон сэргээж тохижуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах зэрэг чухал заалтууд багтаж, цаашид бодит үйл хэрэг болон хэрэгжжээ. Энэ явцад зарим нэгэн зохицуулалтууд ч хийгдэж байсны дотор, БНПАУ-ын техник-эдийн засгийн тусламжаар 1976-1980 онд Хархоринд барихаар төлөвлөсөн мал нядалгааны газрын байршлыг өөрчилсөн шийдвэр гарч байв.

Түүх соёлын дурсгалт барилгуудын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлах асуудал төрийн анхаарлын төвд байж, асуудал эрхэлсэн нэгжүүд ч байгуулагджээ. Үүнд: 1972 онд Улсын барилгын зургийн институтэд “Түүх соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах зураг төсвийн хэсэг”, 1973 онд Соёлын Яамны харьяанд “Түүх соёлын дурсгалт зүйлийн засварын газар”-ыг тус тус байгуулагдан ажиллаж байсныг СнЗ-ийн 1975 оны 47-р тогтоолоор нэгтгэж Улсын барилгын зураг төслийн институтын харьяанд “Түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйлдвэр шинжилгээний товчоо”, 1976 оны 5 дугаар сарын 7-ны 94-р тогтоолоор Барилга-Архитектурын

комиссын харьяа “Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах газар” болгон өөрчлөн зохион байгуулж, аж ахуйн тооцоотой ажиллуулах болжээ.

Тус газар нь Амарбаясгалант, Эрдэнэ зуу, Заяын дурсгалын цогцолбор, Хачин ламын сүм, Гандантэгчэнлин, Дарь-Эхийн сүм, Богд хааны музей, Булган аймгийн Баруун замын байлдааны штаб музей, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Сангийн далай хийд, Гэсэр сүм зэрэг дурсгалт барилгуудыг сэргээн засварлаж, эртний түүх соёлын дурсгал Хэрлэн барс хотын цамхгийн хамгаалалтын зарим ажлыг хийж (МУҮТА. ТБА. Х-446, Д-1, Хн-12, Х.66, 1980), Амарбаясгалант, Эрдэнэзуу дахь хуучны уран барилгыг завсарлан сэргээх ажилд Япон, Вьетнам улсаас мэргэжлийн сэргээн засварлагчдыг урьж ажиллуулжээ.

Соёлын Яамнаас 1981-1990 онд эртний уран барилгыг сэргээн засварлах тухай ойрын ба хэтийн төлөвлөгөөг гаргаж, улс, аймаг, хот, сумдын хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийн үзлэг хийх асуудлыг боловсруулсны гадна зарим аймгийн түүх, соёлын дурсгалт зүйлийн талаар хийж байгаа ажилтай танилцаж зарим шаардлагатай арга хэмжээг авсан байна. (МУҮТА. ТБА. Х-13, Д-2, Хн-611, Х.78, 1979)

1980-аад оны сүүл 1990 оны эхээр Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжсэнээр булш хиргисүүр ухаж малтах, эвдэн сүйтгэх, түүх соёлын дурсгалт зүйлсийг худалдах, хууль бусаар хилээр гаргах явдал ихэссэн хэдий ч гадагш гарсан түүх соёлын дурсгалт зүйлсийг буцаан авчрах талаар багагүй анхаарч, хөөцөлдөж байв. Тухайлбал, 1991 онд Монголын соёл урлагийн хөгжлийн хорооны дэд тэргүүн Н.Энхбаяр, Гандантэгчэнлин хийдийн лам Данзан, зураач, уран барималч Н.Санчир, зохиолч Лха. Дарьсүрэн нарын Монголын соёлын төлөөлөгчид Санктпетербург хотноо айлчилж, Казаны сүмд зочилж Мигжэджанрайсиг бурхны талаар судалгаа хийж, уг уран баримлыг сурвалжлан олох, эх оронд нь эргүүлэн авч ирэх талаар ярилцсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй юм.

Түүнчлэн, нийгмийн ардчилал, шинэчлэлийн үйл явцад, түүх соёлын дурсгалт зүйлийн хамгаалалтад багтсан зарим хөшөө дурсгалыг улс төр, үзэл суртлын шалтгаанаар буулгах болсны эхлэл нь 1951 онд Улсын Төв Номын сангийн өмнө босгосон, улсын хоёрдугаар зэргийн хамгаалалтад байсан И.В.Сталины хөшөөг 1990 оны 2 сард буулгасан явдал байсан бөгөөд ХХ зуунд баригдсан хөшөө, түүхэн дурсгалт барилгуудыг нүүлгэн шилжүүлэх, бүрмөсөн буулгах, нураах ажил үргэлжилсээр байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Түүх, соёлын дурсгалыг эрэн сурвалжлах, хамгаалах, сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэхэд хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгох, судалгаа шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажлыг цогц

байдлаар явуулах явдал чухалчлагдаж, 1990 онд “Соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай”, 1991 онд “Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” хуулиудыг батлан гаргаж, 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” хэмээн заасан билээ.

Энэ бүхний дүнд түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалж хамгаалах, бүртгэж данслах, судалж сурталчлах, сэргээн засварлах ажлын эрх зүйн орчин бүрэлдэж, энэ хүрээнд түүх, соёлын өвийг хадгалах, судлан сурталчлах музей, номын сан, архив, эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагаа шинэ шатанд гарч, хамтын ажиллагаа өргөжих болов.

Conclusion

Legal documents issued for the preservation of historical and cultural monuments define the policy direction to be followed by the state. Regulates all issues related to the legal basis for the protection of historical and cultural monuments within the Republic of Mongolia, the rights and obligations of state institutions. These laws created a legal framework for the preservation, registration, inventory, excavation, research, promotion, and restoration of historical and cultural monuments. Objects held by museums, libraries, archives, intuitions, temples, and individuals, regardless of their form of ownership, have been included in the Mongolian cultural heritage register, providing an opportunity to pass them on to future generations. Thus, the measures taken regarding historical and cultural monuments, the legal framework for their preservation, protection, study, promotion, and restoration have been established. In this context, the work of museums, libraries, archives, and scientific institutions, which are the main institutions for preserving and promoting historical and cultural heritage entered a new phase.

НОМ ЗҮЙ

Б.Ринчен. (1966, 12 18). Түүхийн дурсгалт зүйлийг сахин хамгаалууштай. “Үнэн” сонин, (9982), №352.

Гэгээрэл, шинжлэх ухаан, соёлын талаар холбогдолтой хуульчилсан актуудын системчилсэн эмхэтгэл (1961-1963). (1964). Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Д.Нацагдорж. (1986, 11 16). “Үнэн” сонин, (2165), №276.

М.Шинэхүү. (1961). Түүхийн дурсгалт зүйл, соёлын өвийг хайрлан хамгаалъя. “Шинжлэх ухаан” сэтгүүл, №1, 51-53.

МАХН-аас урлаг-утга зохиолын талаар гаргасан тогтоол шийдвэрүүд (1921-1966). (1967).

Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.

МУУТА. ТБА. Х-13, Д-2, Хн-611, Х.78. (1979).

МУУТА. ТБА. Х-13, Д-2, Хн-66. Х.153-158. (1972).

МУУТА. ТБА. Х-23, Д.1, Хн.137, Х.17. (1935).

МУУТА. ТБА. Х-446, Д-1, Хн-12, Х.66. (1980).

МУУТА. УТНОНББА. Х-4, Д-23, Хн-199, х.176-177. (1957).

МУУТА. УТНОНББА. Х-4, Д.26, Хн.312, Х.188. (1963).

МУУТА. УТНОНББА. Х-4, Д-28, Хн-172, Х.219-220. (1966).

МУУТА. УТНОНББА. Х-4, Д-28, Хн-172, Х.219-220. (1966).

МУУТА. УТНОНББА. Х-4, Д-34, Хн-158, Х.246. (1978).

МУУТА.ТБА. Х-13, Д-2, Хн-62. Х.66. (1972).

Ө.Бүрнээ. (1973). Соёлын дурсгалыг хамгаалахад анхааръя. “Соёл” сэтгүүл, №1, 25-27.

Р.Равжир. (1966, 2 24). Дурсгалт зүйлийг хамгаалъя. “Үнэн” сонин, (9685), №55.

Соёл-гэгээрлийн байгууллагуудын ажлын талаар холбогдолтой зарлиг, тогтоол, заавруудын системчилсэн эмхэтгэл (1940-1961). (1962).

Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Соёл-гэгээрлийн байгууллагуудын ажлын талаар холбогдолтой зарлиг, тогтоол, заавруудын системчилсэн эмхэтгэл. (1940-1961). (1962).

Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Улсын Бага Хурал, Засгийн газраас гаргасан хууль, дүрэм, тогтоолууд. Нэгдүгээр, хоёрдугаар эмхэтгэл дэвтэр. (1941). Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Хураангуй сэтгүүл (№4 ed., Vol. №4). (1922).

Улаанбаатар: Орос, монгол хэвлэлийн газар.

Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм. (1924).

Улаанбаатар: Орос, монгол хэвлэлийн газар.

Ц.Дамдинсүрэн. (1956, 8 19). Соёлын өвийг анхаарч үзье. “Үнэн” сонин, (6410), №195.

Ш.Нацагдорж. (1941). Хуучны дурсгалт зүйлийг сахин хамгаалах нь ямар учраас чухал вэ. “Шинжлэх ухаан” сэтгүүл, №2, 21-23.

Шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхэнд холбогдох баримт бичиг. (1956). “Шинжлэх ухаан” сэтгүүл, №3, 49.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>